



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А77

Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Сэтгэцийн эрүүл мэнд болон донтолын асуудал хариуцсан захирал Доктор Шекар Сахенагийн урилгаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал Л.Насанцэнгэлийг Япон улсын Сайтама хотод зохион байгуулагдах "Гурав дахь шатлалын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар ба өвчтөний аюулгүй байдал" сэдэвт сургалтанд зохион байгуулагч талын зардлаар 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 03 дугаар сарын 19-ний өдрүүдэд оролцохыг зөвшөөрсүгэй.

2. Сургалтад оролцох удирдамжийг хавсралтаар баталж, ажлын тайланг ирсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан танилцуулахыг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирал /Л.Насанцэнгэл/-д үүрэг болгосугай.

3. Дээрх хугацаанд тус төвийн Ерөнхий захирлын албан үүргийг төвийн Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал О.Баатаржаваар түр орлон гүйцэтгүүлсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080256

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 03 сарын 11 өдрийн
А77 дугаар тушаалын хавсралт



СУРГАЛТАД ОРОЛЦОХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Япон улсын Сайтама хотод зохион байгуулагдах “Гурав дахь шатлалын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар ба өвчтөний аюулгүй байдал” сэдэвт сургалтанд 2016 оны 03 дугаар сарын 14-19-ний өдрүүдэд оролцож туршлага солилцох

Хоёр. Сургалт явагдах газар:

Япон улсын Сайтама хотын Нийгмийн эрүүл мэндийн үндэсний институт

Гурав. Үргэлжлэх хугацаа

2016.03.14-19

Дөрөв. Санхүүжилт

ДЭМБ-ын зардлаар *

Тав. Үйл ажиллагааны чиглэл

- ДЭМБ-аас “Гурав дахь шатлалын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар ба өвчтөний аюулгүй байдал”-ын сургалтанд Монгол улсыг төлөөлж оролцох
- Гурав дахь шатлалын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар ба өвчтөний аюулгүй байдал сэдэвт сургалтын аргуудаас СЭМҮТ-д нэвтрүүлэх

Зургаа. Хүрэх үр дүн

- Гурав дахь шатлалын эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар ба өвчтөний аюулгүй байдал сайжрах
- Бусад улс орнуудтай гадаад хамтын ажиллагааг бий болгох